



МОНГОЛ УЛС  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2023 оны 12 сарын 05 өдөр

Дугаар 529

Улаанбаатар хот

Зөвшөөрөл олгох тухай

Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь заалт, 65 дугаар зүйлийн 65.6 дахь хэсэг, 66 дугаар зүйлийн 66.1.6 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны "Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам батлах тухай" 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Төрийн албаны зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Аймгийн биеийн тамир, спортын газрын даргын албан тушаалын тодорхойлолтыг 1 дүгээр, Спортын хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтыг 2 дугаар, Биеийн тамирын хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтыг 3 дугаар, Тогтоол шийдвэр, тайлан мэдээ, хүний нөөц хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 4 дүгээр, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 5 дугаар, Мэдээллийн цахим сан, статистик хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 6 дугаар хавсралт ёсоор батлахыг Биеийн тамир, спортын Улсын хорооны дарга /О.Баттулга/, томилох эрх бүхий албан тушаалтанд тус тус зөвшөөрсүгэй.

2. Төрийн захиргааны албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийн хэрэгжилтийг "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, "Шинэ сэргэлтийн бодлого" дунд хугацааны зорилтот хөтөлбөрт дэвшүүлсэн төрийн бүтээмжийг сайжруулах зорилт, Төрийн албаны хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, шинэтгэлийн үйл явцтай уялдуулан зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Биеийн тамир, спортын Улсын хорооны дарга /О.Баттулга/, томилох эрх бүхий албан тушаалтанд тус тус даалгасугай.

3. Энэхүү тогтоол гарахаас өмнө Төрийн албаны тухай хууль тогтоомжийн дагуу томилогдон ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчийн хууль ёсны эрх ашгийг хангаж, эрх зүйн байдлыг дордуулахгүй байхыг зөвлөсүгэй.

4. Хянаж зөвшөөрөл олгосон албан тушаалын тодорхойлолт тус бүрийг албажуулж, баталж мөрдүүлэх, нэгдсэн санд бүртгэх үйл ажиллагааг мэргэшил, арга зүйн зөвлөгөөгөөр хангаж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Ажлын алба (В.Жавзан)-нд даалгасугай.

5. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 63 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Б.БААТАРЗОРИГ

24000014